

**МОНГОЛ АРДЫН ХӨГЖМИЙН ӨГҮҮЛЭХ ЭРХТЭНТЭЙ ШҮТЭЛЦЭХ
УРЛАГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛСИЙН АНГИЛЛЫН АСУУДАЛД**

Л. Хэрлэн*

Өгүүлэх эрхтэнтэй шүтэлцээт урлаг нь монголчуудын оюуны их соёлд боловсрогдож ардын язгуур шинжийг хадгалж ирсэн урлагийн гайхамшгийн нэгэн бүрдэл билээ. Энэ урлагийн төрөл зүйлүүд зөвхөн монголд төдийгүй дэлхийн олон улс үндэстний язгуур, уламжлалд хадгалагдан хөгжиж ирсэн нь судлаачдын анхаарлыг ихэд татаж тэдний судлагааны бүтээлүүдэд зарим төрөл ангиллаас тэмдэглэгдэж, сүүлийн үед өргөн хүрээтэй судлах ажил явагдаж байна. Ялангуяа монголын ард түмний соёл урлагт хамаарагдах зарим нэр төрөл зүйл нь монгол ардын хөгжмийн ангилалд хэрхэн холбогдох, тэдгээрт өгүүлэх эрхтний оролцоо, шүтэлцээ, үүрэг, онцлог ялгааны талаар тодруулан судлах судлагааны ажил тийм ч хангалттай бус байгаа юм.

Эрдэмтэн судлаач Ж.Бадраа монгол ардын хөгжмийн бүтээлийн ангилалд “Монгол ардын хөгжмийн өгүүлэхүйн эрхтэнтэй шүтэлцээт урлаг” нэгэн ангиллыг тухайлан авч тодорхойлсныг бид мэднэ. Үүндээ *хөөмэйлэх, цуурдах, аялан исгэрэх, аман хуурын, амаар ташиж дэлдэх урлагийг* хамруулан хүний өгүүлэхүйн эрхтэн хөгжмийн зэмсгийн үүрэг гүйцэтгэх юм уу, эсхүүл өгүүлэхүйн эрхтэн хөгжмийн зэмсэгтэй хавсран нэгдэж, тэрхүү зэмсгийн ямар нэгэн эд анги болж байгаагаараа тус төрөл ангилалд хамрагдна хэмээн тодорхойлсон нь бий. Эдгээр төрөл ангиллын онцлог болон ялгаатай шинж байдал, төрөл ангилалд хамруулах нийтлэг зүйлийг судлан гаргаж ирэх асуудал нээлттэй байгаа билээ. Өгүүлэхүйн эрхтэнтэй шүтэлцээт урлагийн талаар хөөмэй, цуурыг эс тооцвол аман хуур, аялан исгэрэх урлаг, амаар ташиж дэлдэх урлагийн төрөл зүйлсээс хараахан судлагааны ажил хөндөгдөөгүй байна. Энэ талаар дараахи тодруулга хийе.

Хөөмэйлэх урлаг нь дууны урлагаас нилээд дээд хэлбэр, хүн хөгжмийн зэмсгийн үүргийг гүйцэтгэж зөвхөн өгүүлэх эрхтнээрээ нэгэн зэрэг олон ая аялгууг үүсгэж чадах боломжийг дээд чинээгээр шавхан үзүүлэх чадамжийг шаардах, авиагаар илэрхийлэгдэж байгаа урлагийн бие даасан нэгэн төрөл юм. Тодотговол “монгол туургатны ухамсарт үйл ажиллагаагаар бүтээгдсэн гоц гайхамшигт үзэгдэл “хүн хөгжим” бол хөөмэй”¹ юм.

Цуурдах урлаг нь хүний өгүүлэхийн эрхтэнээс үүсэх авиан дээр хөгжмийн зэмсэгээс үүсэх авиа хавсран эгшиг аялгуу үүсгэж буй онцлогоороо монгол цуур ялгаатай. Өөрөөр хэлбэл монгол цуурдах онцлог нь хүний өгүүлэхүйн эрхтэн авиа

* МУИС-ийн МХСС-ийн багш, доктор

¹ Л.Хэрлэн (2010) “Монгол хөөмэйн утга холбогдол” 131-р тал, Улаанбаатар.,

үүсгэх явц дээр цуурын авиа нэмэгдэж эгшиглэх арга барил, дуурьсал, нэр төрлийн хувьд хөгжим, хүн хоёрын давхар эгшиг үүсгэх үйл явц юм.

Исгэрэх урлаг нь хүн өгүүлэхүйн эрхтэнээ ая эгшиг үүсгэх хөгжмийн зэмсгийн хэрэглүүр хийх явц, монголчуудын өвөрмөц орчин ахуй, сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой урлагийн нэгэн төрөл юм. Тэгэхдээ дээрх хоёр ангиллаас ялгаатай нь нэг эгшиг аялгууг дуурьсагах, дуу хөгжмийн ая аялгуутай эн зэрэгцэх бүхий л чадамжийг илтгэх боломжтой урлаг гэж хэлж болно. Үүний жишээнд манай ардын урлагт нилээд түгээмэл ажиглагдах исгэрээний олон төрөл (*шүдний, уруулын, тагнайн исгэрээ*) жишээг дурьдаж болно.


Аман хуурдах урлаг нь өгүүлэхүйн эрхтэнд хөгжмийн зэмсгийг аманд тулган барьж хэлийг доргиулан амны хөндийг цуурайлуур (*хөгжмийн цар*) болгон эгшиг аялгуу үүсгэнэ. Энэ урлагийн төрөл нь дээрхи урлагийн төрлүүдээс ялгаатай нь өгүүлэхүйн эрхтний оролцоотойгоор хөгжмийн зэмсэгт эгшиг аялгуу үүсгэдгээрээ ялгаатай.

Амаар ташин дэлдэх урлагт өгүүлэхүйн эрхтнүүд, ам хамрын хайрцагийг цуурайлбар, хий авиан долгионоор ая аялгуу үүсгэж болох чадамжуудыг илтгэх олон төрлүүдийг хамруулан үзнэ. Энэ нь хүний өгүүлэхүйн эрхтний гавлын яс, ам хамрын хөндийг цуурайн хайрцаг, цохилуур хөгжмийн цар болгон, амны хайрцгийн хэлбэрийг өөрчлөх, хацар, шүд, хоолой, шилэн хүзүү, хамар, самсаан дээрээ цохиж янз бүрийн дуу авиа үүсгэх цаашлаад төвөнх хоолойн авиан янз бүрийн цохилгуудаар "*хоолойн лимбэ*", "*шудрагын бөмбөрүүлэн цохих ая*" аялгууны олон хэлбэрүүд юм.

Хүний хоолойноос илүү авиаг хөгийн нийлэмжээр аялгуулах боломжуудыг хэрэглэж чаддаг ямар нэгэн хөгжмийн зэмсэг, аливаа гоц авианууд гэж энэ ертөнцөд ховор ажээ. Аливаа урлагт уран сайхны бүтээлд оролцож буй материаллаг тал нь уран бүтээлийн оюун санааны агуулгыг илэрхийлэгч хэрэгсэл болдогчлон өгүүлэхүйн эрхтэнтэй шүтэлцээт урлагийн материаллаг тал нь авиа үүсгэгч өгүүлэхүйн эрхтэн болдог учиртай. Хөгжмийн дуу авиа нь хөгжмийн зэмсэг, тэрхүү хөгжмийн зэмсгээс гарч буй авиа нь хөгжим, хөгжмийн зохиол, ая аялгуу болдог. Үүнтэй нэгэн адилаар өгүүлэхүйн эрхтэнтэй шүтэлцээт урлагийн төрлүүдийн хөгжмийн зэмсэг нь өгүүлэхүйн эрхтэн юм.

Хүний уушигнаас гарах хийн хуваарилалт, зохицуулалтыг хоолой болон аман хөндийн эрхтэний үйл ажиллагаа, булчингийн агшаалт, тэлэлтээс өгүүлэхүйн авиа, ая аялгуу үүсдэг гэсэн ойлголт юм.

Энэ урлагийн төрлүүд нь өгүүлэхүйн ямар эрхтэний оролцоо, хаана авиа үүсгэж байгаагаас нь шалтгаалан олон янзаар ангилан төрөлждөг. Үүнийг дараах бүдүүвч зургаар үзүүлбэл:



Дээрхи тоймлон авч үзэж байгаа урлагийн төрлүүдийг харьцуулан үзэхэд:

- амьсгаа нь авах, тогтоох, хуваарилах гээд нэгэн дэгийг бий болгох бөгөөд энэ нь хийн хүрд болж авиа үүсгэхэд чухал үүрэгтэйгээр оролцож ирнэ.
- хийн хүрдээр авиа үүсэх явцад өгүүлэхүйн эрхтний аль оронд авиа үүсгэж байгаагаас улбаалан урлагийн төрлүүд ялгагдах онцлог илэрнэ.

Жишээлбэл: төвөнхөд, хөөмэйд, аман хөндийн эрхтэнд зэрэг авиа ая, аялгууг үүсгэснээр *хөөмэйлэх урлаг*, хөөмэйн хөндий, хөгжмийн зэмсэгт авиа үүсгэснээр *цуурдах урлаг*, төвөнхөд эсвэл аман хөндийн эрхтэнд авиаг үүсгэснээр *амаар ташиж дэлдэх урлаг*, зөвхөн аман хөндийн эрхтэний оролцоотойгоор авиа үүсгэснээр *исгэрэх урлаг* харин хийн хүрдний эх үндэс дээр өгүүлэхүйн эрхтний оролцоотойгоор хөгжмийн зэмсэгт авиа үүсгэснээр *аман хуурын* урлаг болдгоороо онцлогтой.

Энэ мэтчилэн хүний өгүүлэхүйн эрхтнээр үүсгэгдэх олон авиа аялгууны нэр төрлүүд байх бөгөөд монголчуудын хувьд ийм жишээнд аялгуут аман зохиолын болон зан үйлийн зарим төрлүүдийг хамруулж болно. Жишээ нь: монголчуудын *баяр, ёслол, хурим найрын ая аялгуу*; хурдан морьдыг уралдуулахын өмнө морь унах хүүхдүүдийн гийнгоо, түрүүлж ирсэн морины цол, сүүлдэж ирсэн дааганы цол, бөхийн цол, гуншинг дуудах, сур, шагайн уухай зэрэг “*Эрийн гурван наадам*”-ын ая аялгуу, *хурим найрын түрлэг*, түүнчлэн дуу чимээний үгс бодит ахуйтай уялдан уриа дуудлагын ая аялгууны урлагийг бүрдүүлсэн “*малын уриа ая*; мал дуудах, саалийн уриа, ангийн уриа ая: анг дуудах, тогтоох ая дуудлага, *уухай ая*; овгийн, байлдааны уриа, ардын тоглоом наадмын уриа урилга, хурайлах, гийнгоо, сур, шагайн уухай, найрын түрлэг, *ушлага дуудлага*; бичиг уншин дуудах, сампин бодлогын ая, хуа дэмбээ, залбирал мөргөл, бөөгийн дуудлага, бөх, морь, тэмээний цол дуудах ая”² зэрэг энэ бүх зан үйл нь хүний өгүүлэх эрхтнээс гарч байгаа авиагаар ан амьтан, мал ахуйтай харьцаж байгаа бодит жишээ юм.

Монголчуудын хувьд хүн байгалийг аргадаж, байгальтай харилцаж амьдралаа зохицуулах үйл ажиллагааны үндсэн дээр мал маллах “*малчин*”, “*нүүдэлчин*” хэмээх өвөрмөц орчин, ахуй, зан үйл, сэтгэлгээнээс өгүүлэхүйн эрхтэнтэй шүтэлцээт урлагийн эх үүсвэрүүд бий болсон төдийгүй өнөөгийн хөгжмийн урлагт холбогдох олон чухал төрлүүд уламжлагдан хөгжиж иржээ.

Эцэст нь хэлэхэд өгүүлэхүйн эрхтэнтэй шүтэлцээт урлагийн төрөл дээрхи ангиллуудаас гадна монголчуудын хүүхдийн аялгуут тоглоом наадмын болон хөдөлмөр, зан үйлийн ая аялгуу, шашны уншлага, ая дан зэргийг судлаж судлагааны эргэлтэнд оруулах асуудал нээлттэй байгааг хэлэх нь зүйтэй байна.

SUMMARY

Mongolian folk art is correlated with speech organs or articulators including *khoomii*, *tsuur*, *isgeree*, *aman huur* or harmonica and *amaar tashih deldeh*. The characteristics of each of them are defined depending on in which part of the speech organs sound is created as the air travels from lungs. For example, if the sound is created in the larynx, *khoomii* organ and oral cavity, it is called *khoomii*; if in oral cavity and labial area, then it is *isgeree* and if the sound is created in musical instrument with the participation of airstream and speech organs, it is called *aman khuur* or harmonica.

² Ж. Бадраа (1998) “*Монгол ардын хөгжим*”, 54-р тал, Улаанбаатар.,